



МОНГОЛ УЛС  
ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2019 оны 10 сарын 01 өдөр

Дугаар А/ЗНН

Мандалговь

Ашигт малтмал тээвэрлэлтийн  
чиглэл батлах тухай

Авто замын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.4, Авто тээврийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.3, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2017 оны 09 тоот тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

Нэг. Баянжаргалан сумын нутагт орших Хөх дэлийн жоншны уурхайгаас Уулын баяжуулах Бор өндрийн уурхай хүртэлх 183 км ашигт малтмал тээвэрлэлтийн авто замын чиглэлийг хавсралтаар баталсугай.

Хоёр. Батлагдсан чиглэлийн дагуух орон нутгийн чанартай авто замыг арчилж хамгаалан, замын тэмдэглэгээ байрлуулж, маршрутын дагуу тээвэрлэлт явуулж байхыг "Монголросцветмет" ТӨҮГ-ын Уулын баяжуулах "Бор-Өндөр" үйлдвэрийн захирал (Б.Магсаржав) -д үүрэг болгосугай.

Гурав. Холбогдох хууль тогтоомж, дүрэм, журам, стандартын хүрээнд батлагдсан маршрутын дагуу тээвэрлэлт явуулж буй эсэхэд хяналт тавьж ажиллахыг сумдын Засаг дарга, аймгийн Авто тээврийн төв (Ц.Бямбацогт), Цагдаагийн газар (О.Амарсанаа), Мэргэжлийн хяналтын газар (Ш.Төрбат), Байгаль орчин аялал жуулчлалын газрын дарга (Н.Гантулга) нарт үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



О.БАТ-ЭРДЭНЭ

488190979